



**НИЙСЛЭЛИЙН
ӨМЧИЙН АШИГЛАЛТ, УДИРДЛАГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 08 сарын 31 өдөр

Дугаар A/246

Улаанбаатар хот

Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн
хариуцсан комиссын бүрэлдэхүүнд
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2014 оны 66 дугаар тогтоолоор батлагдсан “Нийслэлийн өмчит хуулийн этгээдийн эд хөрөнгийн хөдөлгөөн, түүнтэй холбогдох бусад харилцааг зохицуулах журам”-ын 1.2, 7.6 дахь хэсэг, “Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын дүрэм”-ийн 3.3.7 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын дэргэдэх “Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөн хариуцсан комисс”-ын бүрэлдэхүүнийг өөрчлөн, хавсралтаар баталсугай.

2. Эргэлтийн бус хөрөнгийн хөдөлгөөнийг холбогдох хууль, журмын дагуу хэлэлцэн шийдвэрлэж, шийдвэрийн хэрэгжилтийг ханган, өмчийн нэгдсэн бүртгэл, мэдээллийн санд холбогдох хөрөнгийн хөдөлгөөн хийгдсэн эсэхэд хяналт тавьж, ажиллахыг комиссын дарга (Б.Болор-Эрдэнэ)-д, хоёрдогч түүхий эдийн зориулалтаар худалдан борлуулсан хөрөнгийн орлогын төвлөрүүлэлт, зарцуулалтын тайланг улирал бүр нэгтгэн танилцуулж, ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга (Б.Батбаяр)-д тус тус үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Газрын даргын 2021 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн A/215 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.


ДАРГА



М.БАЯРАА

115050000749

Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын
газрын даргын 2021 оны 08 дугаар сарын
31 -ний өдрийн дугаар тушаалын хавсралт



ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ХӨДӨЛГӨӨН
ХАРИУЦСАН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Коммисын дарга:

Б.Болор-Эрдэнэ

Орлогч даргын үүрэг гүйцэтгэгч

Гишүүд:

Б.Батбаяр

Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга

М.Мандах

Өмчийн мэдээлэл, хяналт, ашиглалтын
хэлтсийн дарга

Д.Итгэл

Өмчийн бүртгэл, хувьчлалын хэлтсийн дарга

М.Энхболд

Өмчийн төлөөлөл, менежментийн хэлтсийн
дарга

Комиссын нарийн бичгийн дарга:

Н.Цэцэгдэлгэр

Захиргаа, санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн